МЭДЭЭ · 2025 оны 1-р сарын 13

АВЛИГА, АЛБАН ТУШААЛЫН 7 ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЖЭЭ



Прокурорын байгууллага 2025 оны 01 дүгээр сарын 06-наас 10-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэг бүртгэлтийн 46518, мөрдөн байцаалтын 1697 хэрэгт хяналт тавьж, эрүүгийн 268 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүллээ.

Яллах дүгнэлт үйлдсэн хэргийг тодруулбал, Эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 107, Өмчлөх эрхийн эсрэг 72, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 55, Хүрээлэн байгаа орчны эсрэг 10, Авлига, албан тушаалын 7, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 6, Хүний амьд явах эрхийн эсрэг 4, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 3, Мөнгө угаах 2, Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах болон Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах тус бүр 1 хэрэг байна.

Шүүхэд шилжүүлсэн зарим хэргээс дурдвал:

Нийслэлийн прокурорын газраас Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын харьяа Зорчигчийн вагон депогийн албан тушаалтан Х.З нь ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд бусдаас хахууль авсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 2 /Нийтийн албан тушаалтан хахууль авах/, 22.5 дугаар зүйлийн 1 /Хахууль өгөх/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн

Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтнууд бусдын ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд хахууль авсан, мөнгө угаасан, хахууль өгсөн хэрэгт Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1, 2 /Нийтийн албан тушаалтан хахууль авах/, 22.5 дугаар зүйлийн 1 /Хахууль өгөх/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд;

Хөдөө аж ахуйн их сургуулийн албан тушаалтнууд зах зээлийн дунджаас дээгүүр үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан, бусдын итгэмжлэн хариуцуулсан эд хөрөнгийг завшсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 1.2 /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 17.4 дүгээр зүйлийн 1 /Хөрөнгө завших/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд,

Баян-Өлгий аймгийн прокурорын газраас тус аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын албан тушаалтан С.Е нь албан тушаалын байдлаа ашиглаж, хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авсан хэрэгт Эрүүгийн хуулийн 18.12 дугаар зүйлийн 2 /Хууль бусаар нийгмийн халамж, үйлчилгээ авах/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд,

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газраас Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны албан тушаалтан Б.Б нарын 9 хүнд холбогдох авто замын шалган нэвтрүүлэх боомтын хилийн цогцолборт хяналт шалгалт хийлгэхээр мэдүүлсэн ачаа, барааг шуурхай шалгах, хяналт шалгалтын явцад ачааг буулгахгүй байх, хилийн цогцолбороос гаргаж өгсний хариуд хахууль авсан, хахууль өгсөн хэрэгт Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 2 /Нийтийн албан тушаалтан хахууль авах/, 22.5 дугаар зүйлийн 1 /Хахууль өгөх/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн тус сум дахь сум дундын шүүхэд,

Дорнод аймгийн прокурорын газраас бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн албан тушаалтан Д.Г нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан, анхан шатны баримтаар баталгаажаагүй ажлын гүйлгээг хийж, өөртөө давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд тус тус шилжүүллээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1055